



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Соёл Урлагийн Их сургууль

Хөтөлбөрийн нэр: Менежмент

Индекс: D041302

Шинжээчийн баг:

Ахлагч: Л.Оюунцэцэг Доктор (Sc.D), Профессор

Гишүүд: Н.Батдэлгэр Доктор (Ph.D), Дэд профессор

Х.Сэлэнгэ Доктор (Ph.D), Дэд профессор

Он сар өдөр: 2022-06-10

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

| | | |
|--|--|---|
| Сургуулийн нэр /Монгол, Англи/ | Соёл Урлагийн Их Сургууль Mongolian National University of Arts and Culture | |
| Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/ | Менежмент Management | |
| Индекс | D041302 | |
| Шинжээчид | <ol style="list-style-type: none"> 1. Л.Оюунцэцэг /Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн профессор, шинжлэх ухааны доктор/ 2. Н.Батдэлгэр /Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн дэд профессор, доктор/ 3. Х.Сэлэнгэ /Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Магистр, докторын сургалт, оюутны албаны дарга, доктор, дэд | |
| БМИҮЗ-ийн Мэргэжилтэн | Г.Даваажаргал / БМИҮЗ-ийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн, доктор, дэд профессор/ | |
| Төлөвлөгөө | Он сар өдөр | Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу |
| | 05/11 | Шинжээчийн багийг томилох |
| | 05/11 | Мэргэжилтэн шинжээчдийн багаас ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн |
| | 05/13 | Шинжээчидтэй гэрээ байгуулах |
| | 05/13 | Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгнө |
| | 05/26 | Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. |
| | 05/31 | Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна. |
| | 06/02, 03 | Сургууль дээр очиж шинжээчид ажиллана. |
| | 06/10 | Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. |
| | 06/10 | Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна. |
| | 06/11 | Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд |
| | 06/13 | Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ. |
| | | Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ. |
| Шалгуур шаардлага /журам/ | Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын гуравдугаар хавсралт Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг, шалгуур, шаардлага | |

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Соёлын үйлдвэрлэлийн тэнхим нь 1990 онд Нийгмийн ухааны тэнхим нэртэйгээр байгуулагдаж СУИС-ийн хэмжээнд дээд боловсролын суурь хичээлүүдийг зохион байгуулж ирсэн. Энэ хугацаанд соёл судлалын тэнхим, гадаад хэл, мэдээлэл харилцааны тэнхим, хүмүүнлэгийн тэнхимүүд салбарлан байгуулагдаж, 2011 оноос Менежментийн тэнхим, 2014 оноос Соёлын үйлдвэрлэлийн тэнхим болсон. МЕНЕЖМЕНТ хөтөлбөрөөр 1992 оноос эхэлсэн ба өнгөрсөн хугацаанд 20 удаагийн төгсөлт хийж 600 гаруй мэргэжилтэн бэлтгэжээ.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- БСШУ-ны Сайдын А/174 тоот тушаал (2014.04.28)-аар баталсан Бакалаврын хөтөлбөр боловсруулах нийтлэг шаардлагын дагуу “Менежмент”-ийн мэргэжлээр бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг 2014 онд шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлсэн.
- “Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Соёл урлагийн салбарын хөгжил, хүний нөөцийн эрэлтийн төлөв байдалд STEEP шинжилгээний аргаар дүн шинжилгээ хийж, Нийгэм-хүн ам зүй, Технологи, Эдийн засаг, Хүрээлэн буй орчин (экологи), Улс төр хууль эрх зүйн хүрээний боломж, сорилтууд, ажлын байрны ирээдүйн чиг хандлагыг тодорхойлсон.
- АНУ-ын “San Diego”, “Southem” болон Өмнөд Солонгосын “Hanyang” зэрэг их сургуулиудын сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын үйл ажиллагаа, орчин, дадлага, уран бүтээл, багшийн ур чадвар, оюутны хөгжлийн хөтөлбөр зэргийг судалж, харьцуулалт хийсэн. Мөн ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль, МУИС-ийн Бизнесийн сургууль, ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн ижил төстэй хөтөлбөрүүдийн агуулгатай харьцуулсан судалгааг гаргасан.
- “Менежмент”-ийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд 2018 болон 2020 онуудад өөрчлөлт оруулсан ба сүүлийн өөрчлөлтөөр дээд боловсролын суурь хичээлийн кредитийг багасгаж, мэргэшүүлэх хичээлийг нэмэгдүүлсэн. Мөн 2018 оны сургалтын төлөвлөгөөнд 7 мэргэших чиглэлтэй байсныг 2020 онд өөрчилж, 4 мэргэших чиглэлтэй болгосон (СУИС-ийн Захирлын тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөө, 2018, 2020 он).

- “Менежмент”-ийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг дараах 4 мэргэших чиглэлтэй боловсруулсан. Үүнд: “Ерөнхий менежмент”, “Соёлын менежмент”, “Эвэнт менежмент”, “Хүний нөөцийн менежмент”.
- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэлтэй тодорхойлоход БШУЯ-ны захиалгаар СУИС-ийн хэрэгжүүлсэн “Соёл урлагийн салбар дахь ажлын байрны судалгаа (2019, 2020)”, “Соёл урлагийн үндэсний ажил мэргэжлийн индекс, ангилал ба толорхойлолтод өөрчлөлт оруулах, шинэчлэх боловсруулах төсөл (2019)” зэрэг судалгааны үр дүнгүүдийг харгалзсан.

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Соёл урлагийн салбар дахь ажлын байр, үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт, соёл урлагийн менежерийн ур чадварын судалгаа зэргийг үндэслэн төгсөгчдийн мэргэжлийн хэрэгцээ, ажлын байрны шаардлагыг тодорхойлж, STEEP шинжилгээг хийсэн.
- Гадаад, дотоодын их сургуулиудын ижил төстэй сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний агуулга, сургалтын үйл ажиллагаа, орчин, дадлага, уран бүтээл, багшийн ур чадвар, оюутны хөгжлийн хөтөлбөр зэргийг судалж, харьцуулалт хийсэн.

Анхаарах асуудал:

- Гадаадын их сургуулиудын туршлагаас чухам юуг хөтөлбөрт нэвтрүүлсэн нь тодорхой бус;
- Сургалтын хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэхэд гадаадын их сургуультай хамтарсан болон багш оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх талаар анхаарах нь чухал;

Зөвлөмж:

- Гадаадын их сургуультай хамтарсан болон багш оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилгыг “Менежментийн бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангасан, соёл урлагийн чиглэлээр мэргэшсэн, эх орны төдийгүй дэлхийн түвшинд ажиллах удирдлагын тэргүүлэх зэргийн мэргэжилтэн бэлтгэнэ” хэмээн тодорхойлжээ (Менежментийн бакалаврын сургалтын хөтөлбөр, СУИС, 2022 он, х. 10).
- Хөтөлбөрийн зорилгыг СУИС, СС болон тэнхимийн эрхэм зорилго, зорилтуудтай уялдуулсан байна (Менежментийн бакалаврын сургалтын хөтөлбөр, СУИС, 2022 он, х. 10).

- Хөтөлбөрийн зорилтуудыг тодорхойлохдоо ЮНЕСКО-оос гаргасан боловсролын зорилтууд болон суралцахуйн үр дүнтэй холбож авч үзсэн (Менежментийн бакалаврын сургалтын хөтөлбөр, СУИС, 2022 он, хуудас. 12-14, ӨҮТ, хуудас 15-17).
- Хөтөлбөрөөр төгсөгч мэргэжилтний загвар боловсруулсан.

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хариуцагч Соёлын үйлдвэрлэлийн тэнхим нь 2017-2027 онуудад хэрэгжүүлэх урт хугацааны хөгжлийн стратегийг тодорхойлж, зураглал гаргасан.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “Менежмент” мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулахдаа дээд боловсролын салбарт мөрдөж байгаа хууль, тогтоомж, бодлого, дүрэм, журам, нийтлэг шаардлага, хөтөлбөр, төлөвлөгөө, стандарт, заавар, зөвлөмжүүдийг удирдлага болгосон. Тухайбал, Мэргэжлийн чиглэл, индекс (БСШУ-ны Сайдын А/78 тоот тушаал, 2014.03.13), Бакалаврын хөтөлбөр боловсруулах нийтлэг шаардлага (БСШУ-ны Сайдын А/174 тоот тушаал, 2014.04.28), СУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороо (СУИС-ийн Захирлын 115 тоот тушаал, 2014.05.30) г.м.
- “Менежмент” хөтөлбөрийг 2014 онд СУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцэж баталсан (СУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2014.06.25-ны өдрийн хурлын шийдвэр);
- Менежмент” хөтөлбөрийг нийт 128 кредит цагийн багтаамжтайгаар төлөвлөсөн ба эндээс, Дээд боловсролын суурь хичээлүүд 35 кредит цаг (27.3%), Мэргэжлийн суурь хичээлүүд мөн 35 кредит цаг (27.3%), Мэргэшүүлэх хичээлүүд 50 кредит цаг (39.1%), дадлага 3 кредит цаг (2.3%), төгсөлтийн ажил 5 кредит цаг (4.0%) байна (ӨҮТ, хуудас 20, “Менежмент” бакалаврын хөтөлбөр, Багц баримт бичиг, СУИС, 2022 он);
- Сургалтын төлөвлөгөөний бүтцэд 87% буюу 112 кредит цаг нь заавал судлах, 13% буюу 16 кредит цаг нь сонгон суралцах хичээлүүд байхаар төлөвлөжээ (ӨҮТ, хуудас 20, “Менежмент” бакалаврын хөтөлбөр, Багц баримт бичиг, СУИС, 2022 он);
- “Менежмент” мэргэжлийн хөтөлбөрийн мэргэшүүлэх 4 үндсэн чиглэлийн сургалтын төлөвлөгөө болон хичээлүүд хоорондын уялдаа холбоог гаргасан.
- Хөтөлбөрт SWOT-шинжилгээ хийж, давуу ба сул талууд, боломж, тулгарч болзошгүй аюул болон сайжруулах арга зам зэргийг тодорхойлсон байна.

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- “Менежмент” бакалаврын хөтөлбөрийг БСШУ-ны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан шаардлагын дагуу иж бүрэн байдлаар боловсруулж, баталгаажуулан мөрдөж байна (Сургалтын хөтөлбөрийг баталсан тушаал шийдвэр, баталгаажуулсан сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн стандартууд, бусад холбогдох материалуудыг нэгтгэн хэвлэж, цогц баримт бичиг болгосон).
- СУИС, хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлэгч Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэнхимийн зүгээс ЮНЕСКО, БШУЯ, Соёлын яам болон салбарын мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, томоохон судалгааны ажлууд болон сургалтуудыг нийслэл хот, хөдөө орон нутгуудад үе шаттайгаар явуулж, тэдгээрийн явцад холбогдох байгууллага, ажил олгогчдоос сургалтын төлөвлөгөө, төгсөгчдийн мэдлэг чадварын үнэлгээг авч хөтөлбөрийг сайжруулахад тусгаж ирсэн байна.

Анхаарах асуудал:

- Харьцуулан судалсан гадаадын их сургуулиудын туршлагаас нэвтрүүлэхэд анхаарах;
- Төгсөгчид, ажил олгогчид, бусад сонирхогч талаас хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг системтэйгээр, тогтмол авдаг болоход анхаарах;

Зөвлөмж:

- Харьцуулан судалсан гадаадын их сургуулиудын туршлагаас бодит зүйлсийг нэвтрүүлэх;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг системтэйгээр, тогтмол авч, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах механизм бүрдүүлэх;

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: “БҮРЭН ХАНГАСАН”

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын агуулгыг шинэчлэн сайжруулах хүрээнд тодорхой ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлдэг. Тухайлбал:
 - Хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудыг тодорхойлон, гол оролцогч талыг оюутнууд хэмээн үзэж, сэтгэл ханамжийн судалгаа авч ирсэн ба 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн Cloud системээр авах болсон;
 - Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар –хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн;

- Хөтөлбөрийн үр дүн буюу олгож буй мэдлэг, ур чадвар нь сургалтын агуулгатай хэрхэн нийцэж байгааг шинжилж, дүгнэсэн;
- Хөтөлбөрийн агуулгыг шинэчлэлд оролцогч талуудыг эрэлт хэрэгцээ, саналыг тусгадаг (ӨҮТ, Хүснэгт 2.1, хуудас 24-28, Шинжээчдийн багийн оролцогч талууд /багш, оюутан, төгсөгч, ажил олгогч/-ын төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагын үр дүн);
- Хөтөлбөрийн оролцогч талуудад чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлсон.
- Сургалтын төлөвлөгөөнд орсон мэргэжлийн суурь мэдлэг олгох хичээлүүд хоорондын хамаарал, уялдааг тодорхойлж, схемээр харуулсан (ӨҮТ, Зураг 2.1, хуудас 26);
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүдийн харилцан уялдаа, онол, практикийн харьцаа нь зохистой хэмжээнд байна (“Менежмент” бакалаврын хөтөлбөр, Багц баримт бичиг, СУИС, 2022 он);

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага

- Сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон сайжруулахад мэргэжлийн байгууллага, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг судалж, үндэслэл болгосон байна.
- Сургалтын төлөвлөгөөнд урлагийн хичээлүүд, тухайлбал, хөгжим, бүжгийн хичээлүүдийг сонгон суралцах хэлбэрээр оруулдаг нь оюутнуудад салбарын онцлогийг ойлгуулах, тэднийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.
- СУИС болон сургууль, тэнхмийн зүгээс суралцагчдад практик дадлага туршлага болохуйц олон талт ажил, арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг (Соёлын наадам, Урлагийн гудамж, уран бүтээлийн тоглолтууд г.м.).

Анхаарах асуудал:

- Суралцагчдад төрийн алба, албан харилцаа, бичиг хэрэг, архивын талаар мэдлэг, чадвар олгох, төгсөгчдийг төрийн албанд ажиллахад бэлтгэх тал дээр анхаарах;

Зөвлөмж:

- Суралцагчдын болон ажил олгогчдын хэрэгцээг тогтмол судалж, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход ашигладаг байх;

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн ба үр дүнд суурилсан боловсрол “CDIO”- арга зүйн дагуу хөтөлбөрийн хичээлүүдэд кейсэд суурилсан, төсөлд суурилсан гэх зэрэг аргуудыг ашиглаж байна.

- Хичээлүүд нь лекц, семинар хосолсон хэлбэрээр явдаг. Лекцээр онолын мэдлэг олгож, семинарын ажлын хүрээнд мэтгэлцээн явуулах, практик дасгал, кейсэд суурилсан судалгааны ажлуудыг хийж, онолын мэдлэгээ бататгах байдлаар зохион байгуулдаг байна.
- Түүнчлэн сургууль, тэнхимээс болон мэргэжлийн урлагийн байгууллагуудын зохион байгуулдаг арга хэмжээнүүдийн зохион байгуулалтад оюутнуудыг татан оролцуулж, практик дадлага олгодог (Сургууль, тэнхимийн тайлан мэдээлэл, Шинжээчдийн багаас оролцогч талууд /багш, оюутан, төгсөгч, ажил олгогч/-ын төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагын дүн).
- Хөтөлбөрөөр эзэмшүүлэх ур чадварууд болон цогц чадамжийг сургалт явуулахад баримтлах үндсэн зарчмуудыг тодорхойлсон.
- Мэргэжлийн хичээлүүдийн бие даалтыг хамтарсан, хичээл дундын хэлбэрээр явуулдаг.
- Динамик платформд хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийг бүх хэлбэрээр бүрэн оруулсан.

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр эзэмшүүлэх ур чадварууд болон цогц чадамжийг сургалт явуулахад баримтлах үндсэн зарчимуудыг тодорхойлж, мөрдлөг болгодог;
- Мэргэжлийн хичээлүүдийн бие даалтуудыг хичээл дундын, хамтарсан хэлбэрээр зохион байгуулдаг нь хичээлүүдээр олгох мэдлэг, арга зүйн уялдааг суралцагчдад ойлгуулж, тэдгээрийн хэрэглээний системтэй байдлыг хангах дадлага эзэмшүүлэх сайн талтай;

Зөвлөмж:

- Сургалтын мэдээллийн системийг илүү боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх гол хэлбэр нь шалгалт байна. Семинар, дадлагын ажил, судалгаа, бусад бие даалтын ажлаар эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэхэд төсөл, тайлан хамгаалалт, явцын шалгалт, тест, ангийн ажил болон тэдгээртэй дүйцэх бусад хэлбэрийг ашигладаг.
- Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ 100 онооны системийн ашигладаг бөгөөд багшийн үнэлгээ (явцын үнэлгээ, идэвх оролцооны үнэлгээ) – 70 оноо, улирлын шалгалт- 30 оноо байна.
- Сургалтын төлөвлөгөөнд тусгайлан тэмдэглэсэн, одтой (*) хичээлд 73 С-ээс дээш үнэлгээ авсан нөхцөлд оюутанд кредит тооцох, харин дээрхээс бага оноо авсан тохиолдолд дахин уг хичээлийг сонгон судлах журмын зохицуулалттай.
- Улирал бүрийн болон суралцах хугацааны төгсгөлд оюутан бүрээр Үнэлгээний Голч Дүн (ҮГД) тооцогдоно.

- Оюутан 60 кредит судалсан боловч ҮГД 1.8-аас бага байгаа тохиолдолд цаашид үргэлжлүүлэх шинээр хичээл сонгох эрхийг хязгаарлаж, амжилтгүй үнэлгээ авсан хичээлүүдийг дахин судлуулна.

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудын сурлагын амжилт, чадамжид нөлөөлөх хүчин зүйлсийг судалж, дүн шинжилгээ хийсэн нь тэдний мэдлэг, чадварыг зөв, бодитой үнэлэх, улмаар сургалтын чанарыг сайжруулахад түлхэц үзүүлэх сайн талтай;

Анхаарах асуудал:

- Оюутны мэдлэг, чадвар, хандлагыг зөв бодитой үнэлэх оновчтой, дэвшилтэт арга хэлбэрүүдийг судалж, сургалтад ашиглахад анхаарал хандуулах;

Зөвлөмж:

- Үнэлгээний аргачлалыг хичээл бүрийн хэлбэр, онцлог, агуулгад нийцүүлэн сайжруулах талаар судалгаа хийх, хөтөлбөрийг сайжруулах үйл явцын бүрэлдэхүүнд тогтмол анхаарч үзэж байх нь зүйтэй.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: “БҮРЭН ХАНГАСАН”

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн анги танхимууд (Хичээлийн 2, 3-р байр)
- Хичээлийн төв байр
- Зайн сургалтын лаборатори
- Оюутны хөгжлийн төв (СУИС-ийн төв байр)
- Сэтгэл ханамжийн судалгааг оролцогч талуудаас авдаг
-

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Анхаарах асуудал:

- Нэг оюутанд ногдох хичээлийн байрны зай талбай стандартыг хангадаггүй (ӨҮТ х43-44))
- Орон зайн хувьд алслагдсан хичээлийн хоёр байранд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг.

- Зарим тохиолдолд хичээлийн байр хооронд явахад дараагийн хичээлд амжихгүй байх гэсэн асуудалтай тулгардаг (Багш, оюутны төлөөлөлтэй хийсэн ярилцлага)

Зөвлөмж:

- Хичээлийн байр хоорондын хичээлүүдийг уян хатан зохицуулж, оюутнууд нэг улиралд олон байранд хичээл сонгохуйц нөхцлийг бууруулах ажлын илүү тодорхой болгох

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хичээлийн байранд танилцсан тоног төхөөрөмж
- Оюутнуудтай хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Номын фондыг жил бүр баяжуулдаг.
- Хичээлийн жил бүр сургалтын техник технологид хөрөнгө оруулалт хийдэг.
- OPEN СУИС платформыг хөгжүүлж байгаа
- Багш нар сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлдэг

Анхаарах асуудал:

- Сургалттай холбоотой тоног, төхөөрөмжийг худалдан авах санхүүжилтийн хэмжээ бага.
- Олон төрлийн платформуудыг хольж ашигладаг (OPEN СУИС, Google classroom, Динамик платформ программ (ӨҮТ х50)

Зөвлөмж:

- Лицензтэй программыг авч ашиглах
- Сургуулийн орчинд интернетийг сүлжээг нэвтрүүлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Номын сангийн цахим хуудас
- Удирдлагын мэдээллийн систем

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Номын санд хадгалагдаж буй номын мэдээллийг хангалттай тусгасан.
- OPEN SUIS системд 188 ном байршуулсан

- Е ном, Е сэтгүүлийг байнга баяжуулдаг
- Номын санд КОХА мэдээллийн системийг ашигладаг

Анхаарах асуудал:

- Цахимд байршуулсан номын хувьд оюуны өмчийн асуудалд анхаарах шаардлагатай.

Зөвлөмж:

- Цахим системд байршуулсан сурах бичиг, гарын авлагын оюутны өмчийн асуудлыг шийдвэрлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн хөтөлбөрийн хорооны журам (Захирлын 2014.05.22, №104 тушаалын нэгдүгээр хавсралт)
- Хөтөлбөрийн хороо байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай тушаал (СУИС-ийн захирлын тушаал (2014.05.30, №115))
- Хөтөлбөрийн хорооны бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай (Захирлын 2019.05.14, №А/203)
- “Менежмент” хөтөлбөрийн дэд хорооны хурлын протокол (2018.04.27 болон 2021.05.18-ны өдрийн хурлын протокол)

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаа тогтмолжсон
- Олон төрлийн удирдлагын мэдээллийн системийг ашигладаг (OPEN MNUAC цахим сургалтын динамик систем, UNITCULTURE удирдлагын мэдээллийн систем)
- OPEN MNUAC системийг тасралтгүй хөгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- Бичиг баримтыг цэгцлэх (Хөтөлбөрийн хорооны протокол зэрэг)
- 041302 Менежмент хөтөлбөрийн хүрээнд дөрвөн мэргэшүүлэх чиглэл (Менежмент, Эвент менежмент, Хүний нөөцийн менежмент, Соёлын менежмент) тус бүрээр хариуцах багш байхгүй. Ерөнхийд нь бүгдийг тэнхимийн эрхлэгч хариуцдаг.

Зөвлөмж:

- Сургалтын үйл ажиллагаа, удирдлагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа програм хангамжийн нэрсийг нэг болгох

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тэнхимийн үйл ажиллагааны тайлангууд (2016-2017, 2017-2018 оны хичээлийн жилүүд)
- Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ
 - o University of Zagreb, University of Florence, ӨМӨЗО Хянган аймаг, Ажил мэргэжлийн дээд сургууль, Swiss Cooperation Office гэх мэт
- Монголын инновацын долоо хоногт оролцсон мэдээ, мэдээлэл
- Профессор Ж.Эрхэмтөгсийн танилцуулга
 - o Соёл, урлагийн ажил мэргэжил ба ирээдүй хэлэлцүүлэг
 - o Бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр (Бүсийн сургалтууд)
 - o Соёлын төв, соёлын ордны албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх сургалт
 - o Төрийн захиргааны төв байгууллагын захиалгат ажлууд

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Профессор багш нар идэвхтэй гадаад, дотоодын санхүүжилттэй төсөл хөтөлбөрт хамрагддаг (ӨҮТ х72)
- Гадаадын ИДС-иудтай идэвхитэй хамтран ажилладаг (ӨҮТ х73)
- Төгсөгчдийн холбоог албан ёсоор байгуулсан (ӨҮТ х75)

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны үйл ажиллагааг дэмжсэн санхүүжилтүүд
 - o Төсөв батлах тухай тушаал (2019.05.06 №19) - Маркетинг, менежментийн хөтөлбөрийн оюутнуудын “Creative week” төлөвлөгөөт ажлыг санхүүжүүлэх
 - o Менежментийн олимпиад, соёл урлагийн маркетингийн олимпиад, эдийн засгийн олимпиад оюутан оролцуулах
- СУИС-д судалцагчдад тэтгэлэг олгох журам, СУИС-ийн дүрэм журмын эмхэтгэлүүд
- СУИС-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны журам, СУИС-ийн дүрэм журмын эмхэтгэлүүд
 - o 2.23 Оюутны үйлчилгээний зардалд оюутны эрдэм шинжилгээний болон спорт урлагийн арга хэмжээний зардал, оюутны тэтгэлэг, хөнгөлөлтүүд орно.
- Тэнхимийн багш нарын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, оюутныг дэмжихэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтууд хийгддэг.
- Тэнхимийн багш нар ААНБ-ын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүдийг идэвхтэй хэрэгжүүлдэг

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн цахим хуудас, Фейсбүүк, блог зэргээр тогтмол мэдээлэл түгээдэг (ӨҮТ х61)
 - o <http://m-tenhim.blogspot.com/>
 - o <https://www.facebook.com/culturalindustry/>
- СУИС-ийн Дүрэм, журмын эмхэтгэл (2020)

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн цахим хуудас, Фейсбүүк, блог зэргээр тогтмол мэдээлэл түгээдэг
 - o <http://m-tenhim.blogspot.com/>
 - o <https://www.facebook.com/culturalindustry/>
- СУИС маркетингийн менежертэй болсон

Зөвлөмж:

- Хөтөлбөрийнхөө онцлогийг илүү олон нийтэд таниулах, сурталчлах ажилд анхаарах (Төгсөгчидтэй хийсэн ярилцлага)
- Сургуулийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлэл түгээх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн цахим хуудас, Фейсбүүк, блог зэргээр тогтмол мэдээлэл түгээдэг (ӨҮТ х61)
 - o <http://m-tenhim.blogspot.com/>
 - o <https://www.facebook.com/culturalindustry/>
- СУИС-ийн цахим хуудас дахь дүрэм журам (<https://mnuac.edu.mn/main/485828>)

Шалгуурыг хангасан байдал: “Бүрэн хангасан”

Онцлог зүйл/Туршлага:

- Олон суваг ашиглан мэдээллүүдийг нээлттэй тавьдаг.

Анхаарах асуудал:

- Үндсэн цахим хуудсыг идэвхжүүлэхэд анхаарах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 21–ний өдрийн А/90 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам” – ыг үндэслэн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- 2020 оноос эхлэн цахим бүртгэлийн системийг ажиллуулж элсэлтийн бүртгэлийн явуулдаг болсон. <http://burtgel.mnuac.edu.mn/#/soeregister>
- Шинээр элссэн оюутнуудад зориулсан өдөрлөг үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг. Мөн элсэгч болон бусад оюутанд хичээлийн жилийн нэгдсэн хуанли, бусад шаардлагатай мэдээллийг багтаасан оюутны гарын авлага бүхий оюутны дэвтрийг оюутан бүрд олгодог. (ӨYT хуудас 86, хүснэгт 5.1, Хүснэгт 5.5, хуудас 91, Сургууль дээр ажиллах үеэр)
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах байдал сайн.
- Хөтөлбөрт элсэгчдийг чиглүүлэх зөвлөх багш ажилладаг. (ӨYT хуудас 91, Оюутнуудын уулзалт, Багш нарын уулзалт)

*Шалгуурыг хангасан байдал: “**Бүрэн хангасан**”*

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны үйлчилгээ, хөгжлийн төвийн дэргэд “Мэдээллийн төв” ажиллуулдаг. СУИС-д ирсэн зочид, шинээр элсэгчид болон сонирхсон хэн бүхэнд шаардлагатай мэдээллийг хүргэж ажилладаг.
- “Оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн шалгалт өгч, босго онооны шаардлагыг хангасан оюутныг элсүүлсэн байдалд Захиргаа, дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний газраас дотоод хяналт, үнэлгээ дүгнэлт хийдэг.

Анхаарах асуудал:

- Элсэгчийн тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн оюутны элсэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч, хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийг сайжруулах

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Шинээр элссэн оюутнуудад зориулсан өдрийг жил бүр зохион байгуулдаг. Мөн элсэгч болон бусад оюутанд хичээлийн жилийн нэгдсэн хуанли, бусад шаардлагатай мэдээллийг багтаасан оюутны гарын авлага бүхий оюутны дэвтрийг оюутан бүрд олгодог.

- 2018 онд баталсан “СИУС-ийн оюутны хөгжил хөтөлбөр (2018-2022)-ийг боловсруулан баталж, зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд оюутныг чиглүүлэх, зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлдэг.
- Захирлын 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/146 тоот тушаалын хавсралт “Соёл Урлагийн их сургуулийн оюутны зөвлөх багш ажиллуулах журам”-ын дагуу элсэгч болон суралцагчдад багш нарын зөвлөн тусалж буй байдал сайн. (ӨYT хуудас 91, хүснэгт 5.1, Оюутнуудын уулзалт, Төгсөгчдийн уулзалт)
- 2013 онд оюутанд үйлчлэх, чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Оюутны хөгжлийн төв”-ийг нээсэн. Хөгжлийн төвийн дэргэд сэтгэл зүйчийн саналын хайрцаг ажиллуулдаг.
